



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/64

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хульжийн рашааны хамгаалалтын бүсийг хашаажуулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд

Үнэлгээний хорооны дарга:

- Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

- М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)

- М.Алтанцэцэг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: - Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: - Б.Баярцэнгэл (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010123